



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/1405

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,188,000.00 (нэг сая нэг зуун наян найман мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 166 дугаар сургуулийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль (Б.Хишигбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 166 дугаар сургууль (А.Энхтуяа)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 05 дүгээр сарын 09-ны өдрийн 11 дүгээр тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Сүхбаатар дүүргийн 11 дүгээр сургууль

Д/д	Хөрөнгийн нэр	Ашигласан жил			Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2025 оны 09 сарын 30-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
		7	ш	ш								
1	Самбар	7	ш	3	180,000.00	540,000.00	405,000.00	135,000.00				
Тавилга эд хогшлын дүн												
2	Проектор /epson/	3	ш	1	648,000.00	648,000.00	648,000.00	-			11 дүгээр сургууль	166 дугаар сургууль
Тоног төхөөрөмжийн дүн												
Нийт дүн							1,188,000.00	1,053,000.00	135,000.00			